

## Орхоны хөндийн БЦГ-ын Хамгаалалтын захиргааны

2016 оны 02 сарын мэдээ

02 дугаар сарын 22

### Мэдээлэл, сурталчилгаа

Монгол түмний уламжлалт сар шинийн баярыг тохиолдуулан Хамгаалалтын захиргаа өөрийн харьяанд байдаг 18 ахмад настанууддаа гарын бэлэг гардууллаа.



Сар шинийн баярын өдрүүдэд БОНХАЖЯ-ны 09/782 албан тоот, Хамгаалалтын захиргааны даргын тушаалын дагуу хариуцлагатай жижүүрийн хуваарь гарган албан хаагчид мөрдөж ажиллаа. Баярын өдрүүдэд хариуцлагатай жижүүр хийсэн албан хаагчид Хархорин сумын цагдаагийн хэлтэсийн 70327102 дугаарт цаг үеийн байдлыг мэдээлж хамтарч ажиллаа. Сар шинийн баярын өдрүүдээр хариуцсан газар нутагт гарсан зөрчилгүй, амар тайван байлаа.

Монгол улс, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд Германы сэргээн босголтын зээлийн банкаар дамжуулан хэрэгжүүлж буй “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох” төслийн хүрээнд зарласан дэд төслүүдийн анхан шатны сонгон шалгаруулалтанд тэнцэн дараагийн шалгаруулалтанд оролцох эрхээ авлаа.

Хархорин сум байгуулагдсаны түүхт 60 жилийн ойд зориулсан номонд тавигдах байгууллага, газар нутгийн танилцуулгыг бэлтгэн сумын ЗДТГазарт хүргүүллээ.

Хамгаалалтын захиргааны хягтлан бодогч Р.Хэнчбиш БОНХАЖЯамнаас зохион байгуулсан нягтлан бодогчдод зориулсан сургалтанд хамрагдлаа.

### Байгалийн нөөц хамгаалал, ашиглалт

Байгаль Орчин Ногоон Хөгжил Аялал Жуулчлалын Сайдын 2015 оны А/415-р тушаалыг үндэслэн Орхоны хөндийн БЦГ-ын зөвшөөрөгдсөн бүсэд 2016 оны ойн

цэвэрлэгээний ажил хийлгэх тендерийг зарлан orkhon-valley.mn цахим мэдээллийн хэрэгсэлүүдэд тавьж олон нийтэд мэдээллээ.

Хамгаалалтын захиргаа орон нутгийн төр захиргааны байгууллагатай хамтран тусгай хамгаалалттай газар нутагт газар ашигладаг иргэн аж ахуй нэгжүүдэд шалгалт хийж газар ашиглах гэрээ, байгаль хамгаалах төлөвлөгөө, татвар төлөлтийн байдлыг шалган цаашид авах арга хэмжээний саналыг ТХНУГазарт хүргүүлээ.

### **Хяналт шалгалт**

Хамгаалалтын захиргааны даргын баталсан удирдамжийн дагуу төлөвлөгөөт хяналт шалгалтыг Бат-Өлзий, Хархорин сумдын УТХГНутаг дэвсгэрт хийж байна.

Шалгалтын явцад Бат-Өлзий сумын 1-р багийн иргэн Б.Өлзийбаяр нь Хөнөгийн Таван мод гэх газраас нэг гэрийн унины бэлдэц бэлтгэсэн зөрчил илэрч, үүнд сум дундын Ой ангиар экологи эдийн засгийн үнэлгээ гаргуулан Байгаль орчныг хамгаалах тухай хуулийг үндэслэн 280.416 төгрөгийн нөхөн төлбөр, 960.000 төгрөгийн торгууль ногдуулж, бэлтгэсэн эд зүйлийг хурааж Бат-Өлзий сумын Засаг даргын дэргэдэх захиргааны зөвлөлд хүлээлгэн өглөө.



Хархорин сумын Мойлтын ам, Их Арцат, Бага Арцат зэрэг газруудаар 2-р сарын 05-07-ны өдрүүдэд Этүгэн улаач ТББ-ын тэргүүн Б.Түвшинбаяр, байгаль хамгаалагч Б.Наранхүү нар хамтран эргүүл, шалгалтыг хийж унанги хаягдал түүхээр явж байсан 5 иргэнд Байгаль орчны тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн талаар сурталчилан анхааруулга өгч ажиллаа.